## 3.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явц:

| Эрх зүйн актын нэр | тоо | Зүйл, заалт | Хэрэг жилт (хувиар) | Үүнээс (хувиар) | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 100 | 90 | 70 | 0 | Хугацаа болоогүй |
| УИХ-ын тогтоол | 3 | 8 | 98,7% | 7 | 1 | - | - | |
| УИХ-ын Байнгын хорооны тогтоол | 1 | 1 | 100% | 1 | - | - | - | - |
| Засгийн газрын тогтоол | 2 | 2 | 98,9 | - | 1 | - | - | - |
| **Дүн** | | **3** | **99.2%** | **1** | **2** | **-** | **-** | **-** |

### 3.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг хүснэгтээр үзүүлбэл:

***Хавсралт-3***

| **Шийдвэрийн Д/д** | **Заалт Д/д** | **Шийдвэрийн нэр, огноо дугаар** | **Холбогдох заалтын агуулга** | **Хэрэгжилтийн явц** | **Биеллэлт гаргах нэгж** | **Үнэлгээ** | **Дээд шатны байгуулл** |
|---|---|---|---|---|---|---|---|

| | | | | | | | агын үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| **УИХ-ын тогтоол** | | | | | | | |
| 1 | 1. | Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2016-04-14 Дугаар 2016 №34 | 8.“Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г батлан, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлүүлж байх. | Гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний төсвийн төслийг 2023 оны үйл ажиллагааны зардлын төсөвт тусгасан. Компанийн “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр Өмнөговь аймгийн Цогтцэций сумын гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, Гүйцэтгэх захирал нарын баталсан төлөвлөгөөний 4-р бүлэг “Аюулт үзэгдэл, гамшиг, ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө”-нд газар хөдлөлтийн гамшгийн үеийн хариу арга хэмжээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гамшгийн дараа сэргээн босгох арга хэмжээний талаар ажил, арга хэмжээнүүдийг тусган мөрдөн ажиллаж байна. | СТГ-ТХ, ЕИ-ХЭМАБ | 100% | |
| 2 | 2. | | 1.2. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", | ЗГҮАМХ-ийн 3.6.3. Шаардлагатай материалын нөөц бүрдүүлэлт, замын дээд бүтцийн материалын нөөцийг төлөвлөсөн хэмжээнд бүрэн бүрдүүлж нөөцөлсөн байна.Үүнд: 1. Тавантолгой өртөөний барилга байгууламжуудын цогцолборыг | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2022-11-11 дугаар 2022 №72 | 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил, зураг төсөв болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг 2023 онд шуурхай зохион байгуулах; | Ногоон барилгын шинэ технологи нэвтрүүлж хүрээлэн буй орчныг хамгаалахад үнэтэй хувь нэмэр оруулсан. 2. Зэрлэг амьтны шилжилт хөдөлгөөний нэвтрүүлэх зорилгоор MNS6515:2015 стандартын шаардлагад нийцсэн гарцуудыг төлөвлөж хийсэн. Нийт төслийн хэмжээнд нүхэн гарц 11, нэг түвшний гарцийг 10 байршилд төлөвлөж өгсөн нь зэрлэг амьтан шилжилт хөдөлгөөн хийх боломжийг бүрдүүлсэн. 3. Төмөр замын өртөөний барилгуудын 70-80 хувь шилэн пасадаар баригдсан нь байгалийн гэрэлтүүлэг, дулааныг нэвтрүүлж цахилгаан эрчим хүчийг хэмнэж байна. 2.4. Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сум, Гашуунсухайт боомтод уул уурхайн бүтээгдэхүүнд түшиглэсэн холимог тээврийн терминал байгуулна. Зорилтот түвшин: 2023 он: Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь Биелэлт: 1. Ажлын талбайд олон салаа зам үүсгэхгүй байх зорилгоор маршрутын дагуу түр зам тавьж хөдөлгөөнийг зохицуулж байсан нь агаарын тоосонцор, хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ болсон. 1. Ашиглалт явуулсан болон хуучин ашиглаж нөхөн сэргээлт хийлгүй орхисон түгээмэл тархацтай ашигт малтмалын ордуудын нөхөн сэргээлтийг MNS5917:2008 стандартад нийцүүлэн гүйцэтгэсэн. Нөхөн сэргээлтийг стандартын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэж буй нь байгалийн аясаар сэргэн ургах нөхцөлийг бүрдүүлж байна. Нөхөн сэргээлтийн ажил 96.2 хувьтай байна. 2.Төмөр замын анхны барилга угсралтын явцад үүссэн хаягдал шорооны | ТТЗ ХХК | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | овоолгуудыг бүрэн хэлбэржүүлж орон нутагт хүлээлгэн өгсөн. | | | |
| | 3. | | 1.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийнх нь эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; | 1.Монгол Улсын засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 30 дугаар тэмдэглэлийн XIX.5.; 2.Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэл; 3. Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэлийн XVIII.4 дэх заалтын дагуу Монгол Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 11 өдрийн 72 тоот "Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" тогтоол албажсан. Дээрх шийдвэрүүдийг үндэслэн “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас “Тавантолгой төмөр зам” ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр ирүүлсэн 01/183 тоот албан бичиг ирүүлсний дагуу “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төсөл”-ийн ТЭЗҮ болон иж бүрэн ажлын зураг боловсруулах ажлыг Гүйцэтгэхээр тус компанийн 2023 оны төсөвт тусгасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалтыг явуулж, Хятадын төмөр замын зураг төслийн корпораци ХХК шалгарсан. Тус компанитай 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр гэрээ байгуулж, гэрээний дагуу ТЭЗҮ-г боловсруулах ажлыг гүйцэтгэсэн бөгөөд 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр ЗТХЯ-ны дэргэдэх Шинжлэх ухаан, техникийн зөвлөлөөр хэлэлцэн дэмжигдсэн. Тус ТЭЗҮ-д үндэслэн геодези, зураг зүйн хэмжилтийг | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төслийн талбайд хийж байгаа бөгөөд иж бүрэн ажлын зургийг батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажил хийгдэж байна. | | | |
| | 4. | | 1.5. Төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээдүүд жилийн эцсийн санхүүгийн тайлангаар гарсан цэвэр ашгийн 50 хувь болон төрийн эзэмшилд хамаарах эздийн өмчийн 1 хувьтай тэнцэх дүнгийн аль өндөр хэмжээгээр ногдол ашиг тооцон хуваарилж төсөвт төвлөрүүлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг чиглэл болгон ажиллах; | Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар компани 2022 оны үйл жилийн эцсийн санхүүгийн тайлангаар алдагдалтай ажилласан тул хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.<br>Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн №1 хурлын тэмдэглэлээр Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүйгээр тогтсоныг зөвшөөрсөн. | СТГ | 100% | |
| | 5. | | 1.7. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нэгдсэн цахим бүртгэл, мэдээллийн системийг бий болгох, ашигт малтмал олборлох, боловсруулах, тээвэрлэх зэрэг бүх үе шатанд хамаарах гэрээг | Компанийн хэмжээнд хийгдсэн тээвэрлэлтийн ажлын мэдээг хоног тутамд Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформд өдөр бүр 20:00 цагийн байдлаар мэдээллийг оруулан ажиллаж байна.<br>Төмөр замын тээврийн үйл ажиллагаанд хөтлөгдсөн анхан шатны бичиг баримтуудыг бүртгэх, хянах, боловсруулах, тээврийн болон хөдлөх бүрэлдэхүүний тоон ба чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлох, галт тэрэгний | ЗУГ<br>ЗЭЗХ | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | татварын нэгдсэн системд бүртгүүлж, экспортод гаргах, нууцын зэрэглэлд хамаарах худалдах, худалдан авах гэрээг Улсын Их Хуралд танилцуулах; | хөдөлгөөний зурмаг шинжлэх, шуурхай мэдээ, хатуу тайланг гаргах, тайлагнах. Энэ оны эхний 11 дүгээр сарын байдлаар хоногийн мэдээ 331, сарын тайлан 11, улирлын тайлан 3, хагас жилийн тайлан 1, жилийн эцсийн тайлан 1-ийг тус тус хугацаанд нь гаргаж, Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформд өдөр бүр 20:00 цагийн байдлаар мэдээллийг оруулж, тайлагнан ажиллаж байна. Ашигт малтмал олборлох, боловсруулах үйл ажиллагаа нь тус компанид хамаарахгүй болно. | | | |
| | 6. | Нүүрсний тээвэрлэлт, экспорттой холбоотой асуудлаарх ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2023-01-19 дугаар 2023 №08 | 1/г. г/ Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Монголбанк болон холбогдох төрийн байгууллагуудын нүүрсний тээвэрлэлт, экспорт, үнийн талаар гаргаж байгаа статистик мэдээллийн зөрүүтэй байдлыг судлан үзэж, бодитой мэдээлэл гаргах чиглэлээр анхаарч ажиллах; | Коспанийн хэмжээнд 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 2023 оны эхнээс Тавантолгой- Гашуунсухайт чиглэлд өссөн дүнгээр 364,36 мян.тн нүүрс /чингэлэгтэй экспортын нүүрс 395,97 мян.тн/, Тавантолгой-Цогтцэций чиглэлд өссөн дүнгээр 920,78 мян.тн нүүрс /чингэлэгтэй экспортын нүүрс 979,44 мян.тн/ тээвэрлээд байна. Тээвэрлэлтийн ажлын мэдээг хоног тутамд Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформд өдөр бүр 20:00 цагийн байдлаар мэдээллийг оруулан ажиллаж байна | 90% | | |
| | 7. | | 3/б. нүүрсний тээвэрлэлт, экспорттой холбоотой оффтейк гэрээнүүд, түүнийг нууцад хамааруулсан шийдвэр, ажил гүйцэтгэх, туслан гүйцэтгэх гэрээнүүд, 2010 оноос хойших 1072 | Засгийн газрын 2022 оны 449 дүгээр тогтоолоор төрийн нууцад хамааруулсан “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын төслийн ажил, “Богдхан төмөр зам”-ын суурь бүтэц барих төслийн ажилтай холбоотой гэрээг төрийн нууцаас гаргаж, ил болгохыг даалгасны дагуу 2022 оны А/185 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулж, “Тавантолгой төмөр зам” ХХК-аас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн нууцад | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хувьцаа эзэмшигчдийн нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл, гүйцэтгэх удирдлагын хурлын бүх тэмдэглэл, тушаал, шийдвэр, худалдах, худалдан авах гэрээнүүдийн хуулбарыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу олон нийтэд ил тод болгох; | хамааруулсан баримт бичиг, гэрээ болон тэдгээрийн хавсралтуудыг судалж, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ын дагуу “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын төсөл, “Богдхан” төмөр зам, Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн холболтын төмөр зам, Тавантолгой нүүрс ачих логистикийн төв төслүүдийн маш нууц, нууц зэрэглэлтэй 40 гэрээг ил болгон олон нийтэд мэдээлж, компанийн вэб сайтад байршуулсан. Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос зохион байгуулсан нүүрсний олборлолт, тээвэрлэлт, экспорттой холбоотой асуудлаар ерөнхий хяналтын сонсголд “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын төслийн ТЭЗҮ, холболтын төмөр зам, Түүхий нүүрс ачих логистикийн төв, Богдхан төмөр замын төслийн ТЭЗҮ, бүтээн байгуулалтын ажлуудын нөхцөл байдал, явцын талаар УИХ-ын холбогдох байнгын хороод болон олон нийтэд мэдээлэл хийж0110, нээлттэй болгосон. | | | |
| 2 | 8. | | 3/в. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжид үндэслэн аж ахуйн болон хөрөнгө оруулалтын чиглэлийн аливаа оффтейк гэрээ байгуулахгүй байх, улсын нууцад хамааруулахгүй байх, шаардлагатай | УИХ-ын 2023 оны “1955 оны “Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр” болон “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” 68 дугаар тогтоолын 5-д “энэ тогтоолын дагуу байгуулах аливаа гэрээг ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөл /off-take/-өөр байгуулахгүй байх” гэсэн заалтыг мөрлөн ажиллаж байна. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тохиолдолд Улсын Их Хуралд танилцуулж, хэлэлцүүлэх; | | | | |
| **УИХ-ын байнгын хорооны тогтоол** | | | | | | | |
| 1 | 1 | Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2023-04-25 Дугаар 2023№05 ТБХ | 6г/. төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах. | Үндэсний Аудитын газраас хийсэн “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн Аудитын ажил дуусаж, “Төрийн аудитын тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18-ын 1 дэх хэсэгт заасан дагуу тайлангийн төсөлд санал авахаар 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 01/1421 тоот албан бичиг ирүүлсэн. Энэ дагуу дотооддоо зохион байгуулалтын арга хэмжээ авч тайлан, түүний дүгнэлт хэсгүүдтэй газар, хэлтсийн дарга, инженерүүдийг нэг бүрчлэн танилцуулж зарим дүгнэлтэд хариу санал, тайлбаруудыг бэлтгүүлж, 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдөр “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн “Union building” дэх оффисын хурлын танхимд төслийн гүйцэтгэгч “Бодь интернэшнл” ХХК-ийн төлөөллийг байлцуулан уулзалт зохион байгуулж Аудитын ажлын хэсгийнхэнд танилцуулж хамтран ажилласан. Компанийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг холбогдох баримт, материалын хамт Үндэсний аудитын газарт 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 1/1591 дугаар албан бичгээр хүргүүлсэн. "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн хэрэгжүүлсэн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, түүний зарцуулалт, бүртгэл, | СТГ,<br>ЗУГ | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | явц дундын төлбөрийн баталгаажуулалт, бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, компанийн үйл ажиллагаа, санхүүгийн бүртгэлд Олон улсын хөндлөнгийн аудитын компаниар аудит хийлгэж, дүгнэлт гаргуулах хөндлөнгийн аудит хийлгэх үйлчилгээ үзүүлэх 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн АГГ-2023/33 дугаартай гэрээг "Грант тронтон аудит" ХХК-тай байгуулж, 2024 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хүртэл тайлан зөвлөмжийг эцэслэн ирүүлэхээр ажиллаж байна. | | | |
| **Засгийн газрын тогтоол** | | | | | | | |
| 1. | | Тавантолгой төмөр зам" ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-12 Дугаар 459 | .3.Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд зарцуулсан хөрөнгөд хөндлөнгийн аудит хийлгэж, дүгнэлт гаргуулах, хууль зөрчсөн, ашиг сонирхлын зөрчилтэй, компанийн эрх ашигт нийцээгүй гэрээ хэлцэл, үйл ажиллагааг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Н.Мягмар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Зам, | Үндэсний Аудитын газраас хийсэн “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн Аудитын талбарын ажил дуусч, “Төрийн аудитын тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18-ын 1 дэх хэсэгт заасан дагуу тайлангийн төсөлд санал авахаар 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 01/1421 тоот албан бичиг ирүүлсэн. Энэ дагуу дотооддоо зохион байгуулалтын арга хэмжээ авч тайлан, түүний дүгнэлт хэсгүүдтэй газар, хэлтсийн дарга, инженерүүдийг нэгбүрчлэн танилцуулж зарим дүгнэлтэд хариу санал, тайлбаруудыг бэлтгүүлж, 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдөр “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн “Union building” дэх оффисын хурлын танхимд төслийн гүйцэтгэгч “Бодь интернэшнл” ХХК-ийн төлөөллийг байлцуулан уулзалт зохион байгуулж Аудитын ажлын хэсгийнхэнд танилцуулж хамтран ажилласан. Компанийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг холбогдох | ТТЗ ХХК | 90% | Одоогоор хөндлөнгийн аудитын дүгнэлт эцэслэн гараагүй байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт; | баримт, материалын хамт Үндэсний аудитын газарт 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 1/1591 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | | | |
| 2. | | “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-30 Дугаар 435 | .4. “Богдхан” төмөр зам төсөл болон “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, худалдан авах ажиллагаанд санхүүгийн иж бүрэн хамтарсан хяналт шалгалт хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Төрийн худалдах авах ажиллагааны газар (Ц.Батзул) нарт; | онгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтоор шинээр баригдах хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтын ажлын техник, эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан судалгааны ажил боловсруулахад шаардлагатай хөрөнгийн дүнг "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оын 02 дугаар сарын 16-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан ба "Тавантолгой төмөр зам" ХХК нь мөрдөн ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Боомтын сэргэлтийн хүрээнд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийг хэрэгжүүлэхээр техник, эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан. Хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлэхтэй холбоотой бэлтгэл ажлын явц нийт 30 хувийн гүйцэтгэлтэй байна. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн "...болон "Гашуугсухайт-Ганцмод" хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай 68 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн "Монгол Улсын Их Хурлын 2023 оны 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 4 дэх хэсэгт санхүүжүүлэх арга хэмжээ | ТТЗ ХХК | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | авахыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасан. | | | |

**“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК**